# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр Дугаар 91 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны харьяа Увс, Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн нийт 57,712,636.00 (тавин долоон сая долоон зуун арван хоёр мянга зургаан зуун гучин зургаа) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Дархан-Уул, Увс аймгийн Статистикийн хэлтсийн дарга болон хавсралтад заагдсан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13000300

4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 02 дугаар сарын 20 -ны өдрийн
91 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХИЛИЙН ЦЭРГИЙН 0214 ДҮГЭЭР АНГИ, ХОВД АЗЗА ТӨХХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины марк, улсын болон арлын дугаар. | Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо | Нийт гүйлт (км) | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Цаашид ашиглах хугацаа (жил) | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) | Хүлээн авах байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоёото, Ланд крузер 80, арлын дугаар FZJ800104722, улсын дугаар 5028 УВХ | 2012 | 314,613 | 32,712,636.00 | 3 | 15,000,000.00 | Хилийн цэргийн 0214 дүгээр анги |
| 2 | Ниссан экстрейл, арлын дугаар NT30122750, улсын дугаар 7547 ДАХ | 2012 | 236,159 | 25,000,000.00 | 3 | 12,000,000.00 | Ховд Azza ТӨХХК |
| НИЙТ ДҮН | | | | 57,712,636.00 | | 27,000,000.00 | |
| | | | | (тавин долоон сая долоон зуун арван хоёр мянга зургаан зуун гучин зургаа) | | (хорин долоон сая) | |